

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

6-Р САРЫН 12, 2020

Эдийн засгийн судалгааны алба



Эдийн засгийн өсөлт

Сүүлийн 3 жил дунджаар 5-6 орчим хувийн өсөлттэй байсан эдийн засаг 2020 оны 1-р улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.7 хувиар агшлаа. Ковид-19 холбоотойгоор ХАА, хүнс, ундаа, зарим үйлчилгээний салбараас бусад бүх салбарын үйлдвэрлэл буурсан нь нөлөөлжээ. 2020 онд Монголын эдийн засаг 0.5-1 хувиар агших төлөвтэй байгааг ОУВС, Дэлхийн банкнаас таамагласан байна.

Инфляц

Дөрөвдүгээр сард улсын хэмжээнд инфляцийн түвшин 3.3 хувь, Улаанбаатар хотод 3.4 хувь байна. Инфляцийн ерөнхий түвшний өсөлт саарч байгаа нь голлон тээврийн бүлгийн барааны үнэ 6.8 хувиар буурсантай холбоотой байна.

Хөдөлмөр

2020 оны 1-р улирлын байдлаар ажиллагчдын улсын дундаж цалин 1,260 мянган төгрөгт хүрч өмнөх улирлаас 1 хувиар өсчээ. Дундаж цалинг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харвал уул уурхайн салбарын ажиллагчид 8 хувь, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын ажиллагчдын цалин 6 хувиар өссөн бол худалдаа, тээвэр, үйлчилгээний салбарын ажиллагчдын цалин 1 хувиар буурсан байна. Харин нийт ажиллагчдын тоо өмнөх улирлаас 18.4 мянга буюу 3 хувиар буурчээ.

Гадаад худалдаа

2020 оны эхний 5 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл 14 сая ам долларын алдагдалтай гарлаа. Худалдааны нийт эргэлт өмнөх оноос 28 хувиар, экспорт 39 хувиар харин импорт 14 хувиар буурсан байна. Экспортын орлого ийнхүү буурахад зэсийн баяжмалын экспорт 279 сая ам.доллар, нүүрсний экспорт 761 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин импортын орлого буурахад суудлын болон ачааны авто машины импорт 97 сая ам.доллар, бензин болон түлшний импорт 114 ам.доллараар буурсан нь нөлөөлжээ.

Улсын төсөв

Эхний 5 сарын байдлаар улсын төсвийн тэнцэл 1.6 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан байна. Үүнд төсвийн орлого 9 хувиар буурсан ба үүнд төлбөр хураамжийн орлого 31 хувь, онцгой албан татварын орлого 18 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ. Харин төсвийн зардал 1.1 наяд төгрөгөөр буюу 31 хувиар өссөн нь хөрөнгийн зардлын 58 хувийн өсөлт, урсгал зардлын 27 хувийн өсөлт нөлөөлжээ.

Ханш


Сарын эцэст ам.долларын ханш 2806 төгрөгт хүрч өмнөх оноос 6 хувиар өсчээ. Монгол банкнаас он гарснаас хойш нийт 600 сая ам долларын интервенц хийж зах зээлд валют нийлүүлжээ. Гэсэн хэдий ч гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оноос 22 хувиар буурсан, экспортын орлого 39 хувиар буурч, төлбөрийн тэнцэл 315 сая ам долларын алдагдалтай байгаа энэ үед төгрөгийн ханш аажмаар сулрах эрсдэлтэй байна.



	Үзүүлэлт	Нэгж	2019.05	2020.05	YoY
Бодит сектор	ДНБ өсөлт (2020.03)	%	6.2%	-10.7%	-16.9 pp.
	Ажилгүйдлийн түвшин (2019.12)	%	6.6%	8.1%	+1.5 pp.
Мөнгөний бодлого	Инфляц	%	7.9%	3.3%	-4.6 pp.
	Мөнгөний нийлүүлэлт	Их наяд ₮	20.3	20.56	+1.3%
	Зээлийн үлдэгдэл	Их наяд ₮	17.5	17.2	-1.7%
	Бодлогын хүү	%	11%	9%	-2 pp.
	Ханш (MNT/USD)	₮	2,649.4	2,806	+6%
Сангийн бодлого	Төсвийн орлого	Их наяд ₮	3.9	3.6	-9%
	Төсвийн зардал	Их наяд ₮	3.7	4.9	+31%
	Төсвийн тэнцэл	Их наяд ₮	0.2	-1.6	-680%
Гадаад сектор	Экспорт	Тэрбум \$	3.3	2.0	-39%
	Импорт	Тэрбум \$	2.3	2.0	-14%
	Гадаад худалдааны тэнцэл	Сая \$	0.95	-0.14	-99%
	Төлбөрийн тэнцэл (2020.04)	Сая \$	103	-315	-306%
	ГВАН (2020.04)	Сая \$	3,759	3,844.2	+2%


Эдийн засгийн өсөлт

- Бодит дотоодын нийт бүтээгдэхүүний өмнөх мөн үетэй харьцуулсан өсөлт
- Бодит дотоодын нийт бүтээгдэхүүний улирлын өсөлт /улирлын нөлөөллийг арилгасан/
- Poly. (Бодит дотоодын нийт бүтээгдэхүүний өмнөх мөн үетэй харьцуулсан өсөлт)




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Ажилгүйдлийн түвшин




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Улсын төсвийн тэнцэл




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Мөнгөний нийлүүлэлт




Инфляци




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Гадаад худалдааны тэнцэл




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Төлбөрийн тэнцэл




Гадаадын шууд хөрөнгө оруулалт

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт /Хуримтлуулсан, Сая ам.доллар/
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт /Тухайн сарын, Сая ам.доллар/




Гадаад валютын нөөц




Эх сурвалж: Монголбанк

Улсын гадаад өр


■ Гадаад өр /Сая ам.доллар/ ■ Улсын гадаад өр болон нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа



Ам.долларын ханш



Хүү



Эдийн засгийн судалгааны алба:

Шинжээч

Г.Батзориг

МУИС-ийн эдийн засгийн ухааны бакалавр, Турк улсын Сакаръя их сургуулийн эдийн засгийн ухааны мастер

Утас: 90171210

Имэйл: Batzorig_g@golomtbank.com

Шинжээч

Э.Батхорлоо

МУИС-ийн эдийн засаг, статистикийн бакалавр

Утас: 99090533

Имэйл: Batkhorloo@golomtbank.com

Эх сурвалж

1212.mn

mongolbank.mn

Голомт банкны дотоод эх сурвалж

Голомт банкны эдийн засгийн судалгааны алба нь макро эдийн засгийн судалгаа болон таамаглалуудыг дотоод ажилчид, харилцагчид болон олон нийтэд хүргэн ажилладаг. Тус тайланд 2020 оны 4, 5-р сарын тоон мэдээлэл болон зарим тохиолдолд 2019 оны 4-р улирлын тоон мэдээллийг ашигласан болно. Энэхүү судалгаа нь зөвхөн банкны дотоод хэрэгцээнд зориулсан бөгөөд Голомт банкны үзэл баримтлалыг илэрхийлээгүй болно.